



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-6

---

1. *“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/* 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 6 дугаар сарын 15-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 20 цаг 46 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: Ц.Даваасүрэн, Б.Чойжилсүрэн;  
Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Ж.Батсуурь;  
Тасалсан: Ш.Раднаасэд.*

**Нэг. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй, гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 20 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 20 цаг 48 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА**

**Г.ТЭМҮҮЛЭН**

**Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим  
20 цаг 46 минут

### **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул өнөөдрийн Төсвийн байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлэн хуралдъя.

Ингээд нэг асуудал байгаа. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Үүнээс өмнө ирцийг Та бүхэнд танилцуулъя.

Ч.Хүрэлбаатар гишүүн,  
Д.Өнөрболор гишүүн, Б.Жавхлан сайд,  
Л.Мөнхбаатар гишүүн, Д.Тогтохсүрэн  
гишүүн, Ж.Батсуурь гишүүн, Ц.Сандаг-  
Очир гишүүн, Х.Булгантуяа гишүүн,  
Б.Пүрэвдорж гишүүн, С.Одонтуяа

*Хуралдаан 2 минут үргэлжилж, 20 цаг 48 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

гишүүн, ингээд миний бие гээд нийт 11 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөл болоод Улсын Их Хурлын даргаас чиглэл болгосон гүйцээн найруулах, гүйцээн боловсруулах чиглэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив. /алх цохив/

Ингээд “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие өөрөө танилцуулъя. /алх цохив/

Ингээд тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.

**Ц.АЛТАН-ОД**